

УРЬДЧИЛСАН ТАЙЛАН №.2
2013 оны 6 дугаар сарын 4–14-ний өдрүүд

2013 оны 6 дугаар сарын 19-ний өдөр

I. ТОВЧ ХУРААНГУЙ

- Сонгуулийн сурталчилгаа идэвхтэй боловч тайван үргэлжилж байна. Нэр дэвшигчдийн сурталчилгаа нь аймаг орон нутагт харилцан адилгүй явагдаж байгаагаас гадна нэр дэвшигчид болон тэдний төлөөллийн дунд телевизийн халз мэтгэлцээн өрнөхгүй байна.
- Сөрөг хүчин санал тоолох автомат төхөөрөмж (СТАТ)-д үл итгэж, саналын хуудсыг гараар давхар тоолох санал гаргасан нь намуудын байр суурийг тодорхой хэмжээгээр хуваагдахад хүргэв. Монгол Ардын Нам (МАН)-аас нэр дэвшигч Б.Бат-Эрдэнэ саналын хуудас гараар давхар тоолохыг уриалснаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль (МУЕСТХ)-ийг зөрчсөн гэж эрх бүхий байгууллагаас анхааруулга авлаа. Түүнчлэн Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиар хориглосон байтал Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж сурталчилгаандаа мөнгө санхүүтэй холбоотой амлалтыг өгсөөр байв.
- Сонгуулийн Ерөнхий Хороо (СЕХ) сонгуулийн бэлтгэл ажлаа үргэлжлүүлсээр байгаа хэдий ч доод шатны сонгуулийн хороо (ДШСХ)-д хэрхэн ажиллах талаар бүрэн журам боловсруулж, зохицуулалт хийгээгүй хэвээр байна. Саналын хуудас хэвлэх ажил дуусч, сонгуулийн хэсгийн хороо (СХХ)-дын сургалт зарим газарт үргэлжилж байна. СЕХ сонгуулийн өдрөөс өмнө СТАТ-ийг орон даяар туршихаар төлөвлөж байна.
- Сонгогчдын жагсаалтыг СХХ-дод түгээсэн боловч ЕАБХАБ/АИХЭГ-ын Сонгуулийг ажиглах хороо (САХ)-ны урт хугацааны ажиглагч (УХА)-дын очиж үзсэн СХХ-дын нэлээд олон байранд уг мэдээллийг дэлгэж тавиагүй байгаа нь сонгогчдын бүртгэлээ баталгаажуулах хугацааг багасгахад бодитоор нөлөөлж байна.
- Шударга өрсөлдөөн хэрэглэгчдийн төлөө газар (ШӨХТГ) нь хэвлэл мэдээлэлтэй холбоотой хэд хэдэн гомдол хүлээн авч шийдвэрлэжээ. Тухайлбал, нэр дэвшигч Б.Бат-Эрдэнийн сонгуулийн сурталчилгааны урианы нэг үгийг зориудаар буруу хэлсэн гэж үзээд, холбогдох сэтгүүлчдэд мөнгөн торгууль оногдуулсан байна. СЕХ-ны дэргэдэх орон тооны бус Хэвлэл мэдээллийн зөвлөл зөвхөн нэг удаа хуралдаж, өнөөг хүртэл ямар нэг гомдол хүлээж аваагүй байна.
- ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-нд мэдээлснээр сонгуулийн сурталчилгаатай холбоотой хуулийн заалтыг хэрэгжүүлэхийн тулд хэвлэл мэдээллийн хэрэгслүүд сонгуулийн сурталчилгааны мэдээллийг бүх нэр дэвшигчдэд тэнцүү байхаар явуулахаас гадна улс төрийн сурталчилгааг ч ижил байдлаар явуулна. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-ны хийсэн хэвлэл мэдээллийн анхны мониторингийн үр дүнгээс харахад МҮОНРТ-ийн хувьд энэ мэдээлэл үнэн байна. Одоогийн байдлаар нэр дэвшигчдийн дунд телевизийн халз мэтгэлцээн зохион байгуулагдаагүй байна.
- Одоог хүртэл СЕХ нь өөрт ирсэн бүх өргөдөл гомдолтой танилцуулах боломжийг ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-нд олгоогүй байгаа хэдий ч аймаг, нийслэлийн сонгуулийн хороо (АНСХ)-дын бүрэлдэхүүнтэй холбоотой 39 гомдол хүлээж аваад байгаагаас мэдээллээ. СЕХ

нь эдгээр өргөдөл гомдлыг шийдвэрлэхдээ 22 АНСХ-дын 9-ийнх нь гишүүдийг өөрчлөн томилжээ. Хороодын бүрэлдэхүүнтэй холбоотой гомдлыг барагдуулах тал дээр СЕХ-ноос гаргасан шийдвэрүүд нь үндэслэл, нотлох баримт дүлмаг байгааг САХ болон САХ-ныхонтой уулзсан бусад хүмүүс хэллээ.

- Зөвхөн ганц төрийн бус байгууллага (ТББ) “Мидас” энэ сонгуулийг ажиглах санхүүжилтийг олж авсан бөгөөд энэ нь СТАТ-ийн ажиллагааг ажиглахад голлон чиглэгдэнэ. Бусад ТББ-ууд сонгуулийн өмнөх үеийг ажиглахгүй байгаа нь сонгуулийн өмнөх хугацаанд ажиглалт явуулах итгэмжлэл олгох СЕХ-ны зохицуулалт, журмаас үүдэж байна.

II. СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ОРЧИН

Сонгуулийн сурталчилгаа идэвхтэй, ерөнхийдөө тайван явагдаж байгаа ч, ялангуяа автомат төхөөрөмжөөр санал тоолохтой холбоотойгоор халуухан орчин бүрдэж байна. Өнөөгийн Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж болон түүнийг дэвшүүлсэн Ардчилсан Нам (АН)-ын зүгээс санал тоолох автомат төхөөрөмж (СТАТ)-ийг ашиглах ач холбогдлыг “шударга ёсыг дээдлэх ашиг сонирхолд нийцнэ”¹ гэж удаа дараа онцолж байхад, МАН-аас нэр дэвшигч Б.Бат-Эрдэнэ болон МАХН-аас нэр дэвшигч Н.Удвал нар СЕХ-ноос гаргасан сонгогчдод зориулсан мэдээлэл хангалтгүй гэж үзэхийн зэрэгцээ автоматаар болон гараар тоолсон дүн дүйцэхгүй тохиолдолд СЕХ-ноос үүнийг зохицуулах зохицуулалтгүй байна гэж онцолж байлаа.²

6-р сарын 5-ны өдөр нэр дэвшигч Б.Бат-Эрдэнэ автоматаар санал тоолох нь ил тод биш, сонгогчид үл итгэдэг гэх үндэслэлээр хүн ам ихээр төвлөрсөн аймаг, хотуудад³ саналын хуудсыг гараар тоолох саналд нэгдэхийг нөгөө хоёр нэр дэвшигчиддээ хандан уриалав. Үүний хариуд СЕХ нь 6-р сарын 6-ны өдөр МАН-д албан бичгээр МАН-ын нэр дэвшигч Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль (МУЕСТХ)-ийг зөрчихийг уриалахгүй байхыг шаардав.⁴ Түүнчлэн ШӨХТГ нь АН-аас ирүүлсэн гомдлын дагуу шалгаад, нэр дэвшигч Б.Бат-Эрдэнийн уриалгыг МУЕСТХ-ийн 33.7.7 дахь заалтыг зөрчсөн гэж түүнд анхааруулга өгөв. МАН саналыг гараар тоолох талаар ухуулгаа үргэлжлүүлэхээ САХ-нд хэллээ.

Энэ сонгууль нь 2012 оны УИХ-ын болон орон нутгийн сонгуультай адил нэр дэвшүүлсэн намууд аймаг, орон нутагт хэр их дэмжлэгтэй байгаа, түүнчлэн нэр дэвшигчдийн санхүүгийн байдлаас улбаалан сонгуулийн сурталчилгаа орон нутагт мэдэгдэхүйц ялгаатай явагдаж байна. Бүх нэр дэвшигчид аймгийн төвүүд, нийслэлийн дүүргүүдээр сонгуулийн сурталчилгааг явуулж байхад, тэдний төлөөллүүд нь хөдөө сумдад ажиллаж байна. Мөн түүнчлэн Монгол Улсын Ерөнхий сайд, УИХ-ын дарга, яам, агентлагуудын газрын дарга нар, Ерөнхийлөгч болон Ерөнхий сайдын зөвлөхүүд, Ерөнхийлөгчийн Тамгын Газрын дарга нар одоогийн

¹ Тухайлбал, 4-р сарын 29-нд Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан Ардчилсан орнуудын 7-р чуулганд хэлсэн үгэндээ Монгол Улсын Ерөнхийлөгч СТАТ-ийн ач холбогдлыг онцлон тэмдэглэжээ. <http://cdmongolia.mn/statements/>

² МАН нь автоматаар санал тоолохыг нэвтрүүлэхийн төлөө саналаа өгсөн парламентад суудалтай намуудын нэг юм. Харин 2012 оны УИХ болон орон нутгийн сонгуулийн дүнг гаргахад автомат тооллого болон гар тооллогын дүн зөрүүтэй байна гэж тус нам ярих болжээ.

³ Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон, Хөвсгөл аймгууд.

⁴ Зууны мэдээ сонины 6-р сарын 6-ны дугаарт Б.Бат-Эрдэний уриалга нийтлэгдсэн. Тэр өдөр нь АН уг уриалгыг МУЕСТХ-ийг зөрчсөн гэж үзэж ШӨХТГ-т гомдол гаргасан байна. СЕХ 6-р сарын 7-нд өөрийн цахим хуудсанд (<http://gec.gov.mn/details/772>) мэдэгдлээ тавьж, нэр дэвшигчийн уриалга нь МУЕСТХ-ийн 55.13-р зүйл (сум, дүүргийн сонгуулийн хороо харьяа бүх хэсгээс санамсаргүй сонголтын аргаар сонгож хяналтын тооллого хийлгүүлнэ), 33.7.7-р заалт (нэр дэвшигч нь сонгуулийн хуулийг зөрчихийг уриалахыг хориглоно)-ыг зөрчиж буй хууль бус үйлдэл бөгөөд 33.19-р заалт (33-р зүйлийг зөрчсөнд оногдуулах захиргааны хариуцлага)-ын дагуу хариуцлага хүлээх ёстой гэж үзэв. Түүнчлэн АН-аас СЕХ-ны байр суурийг дэмжиж, Өдрийн сонины 6-р сарын 10-ны өдрийн дугаарт нийтлэл хэвлүүлж, ийм уриалга нь МУЕСТХ-ийг зөрчиж байгааг нэр дэвшигчид мэдэх ёстой гэж тэмдэглэв.

Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгаанд оролцож, үг хэлж байгааг САХ ажиглалаа. Ерөнхийдөө бүх нэр дэвшигчдийн сурталчилгаанд яамдын сайдууд, УИХ-ын дэд дарга, УИХ-ын гишүүд, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын гишүүд, засаг дарга нар болон үндэсний бөх, сумо бөхийн аваргууд, эмч, жүжигчин, зохиолч, яруу найрагч гэх мэт олны танил алдартнууд оролцож байгаа нь ажиглагдлаа.⁵ Хэдийгээр зарим газар нэр дэвшигчдийн үйл ажиллагаа нэг дор ойрхон явагдаж байсан ч элдэв хэрэг зөрчил гарсангүй. Одоогийн байдлаар ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ нь орон даяар сонгуулийн сурталчилгааны 35 арга хэмжээн дээр ажиглалт хийгээд байна.⁶ Намын сонгуулийн сурталчилгааныхан, тэр дундаа АН, МАН-ынхан айл өрхүүдээр явж, сурталчилгаа хийж байна. Мөн худалдаа үйлчилгээний төвүүд, хотын төв гудамж, талбай зэрэг газруудад сонгогчидтой уулзалт цуглаан хийх, сонгуулийн сурталчилгааны гэр, намын байруудаар нэр дэвшигчийн сурталчилгааны материал, танилцуулга зэргийг тарааж байна. Туг далбаа, сурталчилгааны самбар болон бусад хэвлэмэл материалууд дунд зэрэг харагдах байдалтай байна. Зарим дүүрэгт нэр дэвшигч сурталчилгааны арга хэмжээ зохион байгуулахаар ирэхээс өмнөх өдөр л сонгуулийн сурталчилгаа тавигдах тохиолдол ч байв. Нэр дэвшигчид мөн Фэйсбүүк, Твиттер ашиглахаас гадна гар утасны мессежээр сонгуулийн сурталчилгаагаа явуулж байна.

Сонгуулийн сурталчилгаа нь нэр дэвшигчид, эсвэл тэдний төлөөллийн хооронд шууд халз мэтгэлцээнгүй өрнөж байгаагаараа онцлог байна. Бүх нэр дэвшигч мөрийн хөтөлбөртөө авилгатай тэмцэх, ажилгүйдлийг бууруулах, уул уурхайгаас үүдэх нийгэм, байгаль орчин, эдийн засаг болон засаглалд үзүүлэх сөрөг нөлөөг багасгах, архидалттай тэмцэх, мөн түүнчлэн шүүхийн шинэчлэл, төрийн албыг улс төрийн нөлөөлөлгүй болгох, хүн амын амьжиргааг дээшлүүлэх, боловсрол, эрүүл мэндийн салбар дахь хөрөнгө оруулалтыг дэмжих, ОХУ болон БНХАУ-тай сайн харилцааг эрхэмлэх гадаад бодлогоо үргэлжлүүлэх зэрэг асуудлыг багтаажээ. МУЕСТХ-ийн дагуу төсөв мөнгөтэй холбоотой амлалт, түүнчлэн Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд хамааралгүй бусад амлалтыг хориглосон байдаг. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-ны урт хугацааны ажиглагч (УХА)-дын зүгээс нэр дэвшигч Ц.Элбэгдорж нэлээд хэдэн удаа мөнгө санхүүтэй холбоотой амлалт өгснийг тэмдэглэжээ.⁷ Тухайлбал 2013 оны улсын болон орон нутгийн төсвөөр дамжуулан Дорнод аймагт хэд хэдэн хөтөлбөр хэрэгжүүлэх, залуу эхчүүдэд хүүхэд асрах тэтгэмжийг хоёр жилийн хугацаатай олгох, цэцэрлэгийг гэр болон албан газарт нь байгуулах, тав ба түүнээс дээш хүүхэд өсгөж, асарч буй эхчүүдэд жил бүр нэг сая төгрөгний тэтгэмж олгох гэх мэт амлалт өгчээ. МАН-аас эдгээр амлалтуудын талаар хэд хэдэн гомдол гаргасан ба үүнд Ц.Элбэгдоржийн 5-р сарын 22-нд Дорнод аймагт сонгогчидтой уулзах үеэрээ өгсөн амлалтуудын талаар 5-р сарын 25-ны өдөр Нийслэлийн цагдаагийн газарт гомдол гарган, хувийг СЕХ-нд хүргүүлжээ.

Ш. СОНГУУЛИЙН ЗАХИРГАА

СЕХ нь хуулийн хугацаандаа багтаан сонгуулийн бэлтгэл ажлаа үргэлжлүүлж байгаа хэдий ч доод шатны сонгуулийн хороо (ДШСХ)-дын ажиллагааг бүрэн зохицуулах журам боловсруулаагүй, мөн хороодод зориулж сонгуулийн хуулийн холбогдох заалтуудын талаар тодорхой тайлбар, зааварчилгаа гаргаагүй хэвээр байна. МУЕСТХ-нд ойлгомжгүй, зарим тохиолдолд хоорондоо зөрчилдсөн заалтууд бий ч, сонгуулийн процедур нэг мөр хэрэгжих

⁵ МУЕСТХ-иар улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч сонгуулийн сурталчилгаа (33.7.11-р зүйл)-нд оролцохыг хориглосон. 6-р сарын 10-ны өдөр МАН-аас Нийслэлийн цагдаагийн газарт ДБЭТ-ын захирал өнөөгийн Ерөнхийлөгчийг дэмжин, сурталчилгаанд оролцож буй талаар гомдол гаргав.

⁶ ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-ны УХА-чид гурван нэр дэвшигчийн Улаанбаатар хот, Баян-Өлгий, Дархан-Уул, Дорнод, Говь-Алтай, Хөвсгөл, Хэнтий, Сэлэнгэ, Төв, Завхан аймгуудад болсон сонгуулийн сурталчилгааны арга хэмжээг ажиглав.

⁷ 5-р сарын 22-нд Дорнод аймгийн Чойбалсан, 6-р сарын 4-нд Говь-Алтай аймгийн Алтай, 6-р сарын 6-нд Баян-Өлгий аймгийн Өлгий, 6-р сарын 9-нд нийслэлийн Чингэлтэй дүүрэгт иргэдтэй уулзах үе.

эсэхийг сонгуулийн өдөр ажиглах л үлдлээ.⁸ Сум, дүүргийн сонгуулийн хороо (СДСХ)-д нь хэсгийн хороодод ажиллах хүмүүсийнхээ сургалтыг эхэлсэн байна.

Бүх шатны сонгуулийн хороодын гишүүд төрийн албан хаагчид байх ёстой. САХ-ны зарим урт хугацааны ажиглагчидтай ярилцсан зарим хүмүүсийн хэлснээр бүх шатны сонгуулийн хороодод томилогдон ажиллаж буй төрийн албан хаагчид нь АН-тай холбоотой хүмүүс байна гэсэн ойлголт байгааг мэдээлэв.⁹

Уулзаж ярилцсан хүмүүсийн зарим нь СТАТ-д итгэлгүй байгаагаа илэрхийлсээр байгаа ч, СЕХ болон уг төхөөрөмжийг үйлдвэрлэгчид нь сонгогчид хийгээд сонгуулийн хороодын дийлэнх гишүүд автоматаар санал тоолохыг дэмжиж байна гэж үзэж байна. СЕХ нь 6-р сарын 21-нээс 23-ны хооронд аль нэг өдөр СТАТ-ийн ажиллагаа болон сонгуулийн хэсгийн хороо (СХХ)-доос СЕХ-нд мэдээлэл дамжуулах үйл ажиллагааг орон даяар турших хяналтын шалгалтыг явуулахаар төлөвлөж байна.

Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар болон Залуучуудын холбооноос санаачилсан, сонгуульд идэвхтэй оролцож, саналаа өгсөн хүн бүрт 1000 төгрөг (0.50 орчим евро)-тэй тэнцэх гар утасны нэгжээр урамшуулах санаачилгыг СЕХ 6-р сарын 13-ны өдөр дэмжив.¹⁰

СЕХ хилийн чанадад суугаа сонгогчдод зориулсан саналын хуудсыг хэвлүүлэн, гадаад улсуудад байгуулагдсан 39 хэсгийн хороонд илгээв. Монгол улсад саналаа өгөх сонгогчдын хэсгийн хороодын саналын хуудсыг 6-р сарын 8-наас 10-ны өдрүүдэд хэвлэлээ.¹¹ Хэвлэх ажлыг нэр дэвшигч бүрийн нэрийн өмнөөс хоёр намын ажиглагчид ажиглав. Саналын хуудсыг бүх аймаг, нийслэлийн сонгуулийн хороодод 6-р сарын 12-ны өдөр хүргүүлэв.

Сонгогчдын жагсаалтыг урьдчилсан байдлаар хэвлэн, 6-р сарын 6-ны өдөр буюу хуульд заасан хугацаанд багтаан, хэсгийн хороодод түгээж дууссан хэмээн САХ-ны УХА-чид мэдээлэв. Уг жагсаалтыг хүлээж авсныхаа дараа сонгуулийн хэсгийн хороод өөрсдийн байранд, эсвэл орон нутгийн захиргааны байранд олон нийтэд танилцуулах үүднээс ил тавих ёстой. Гэвч энэхүү тайлангийн хугацаанд ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-ны урт хугацааны ажиглагч (УХА)-дын очиж үзсэн СХХ-дын нэлээд олон байранд сонгогчдын нэрсийн жагсаалтыг дэлгэж тавиагүй байгаа нь сонгогчид жагсаалтад буй мэдээллээ баталгаажуулах 10 хоногийн хугацааг багасгахад бодитоор нөлөөлж байна.

Хэсгийн хороод айл өрхүүдээр явж, сонгууль өгөх урилга тараан, сонгогчийн бүртгэлийг баталгаажуулж эхэлсэн байна. Ерөнхийдөө улс төрийн намуудын төлөөлөлтэй уулзахад сонгогчдын бүртгэлийн тогтолцоо, сонгогчдын нэрийн жагсаалтын үнэн зөв байдалд итгэлтэй байгаагаа илэрхийлж байв. Улсын бүртгэлийн ерөнхий газраас 6-р сарын 6-ны өдрөөс эхлэн сонгогч бүртгэлээ хийлгэж, мэдээллээ шалгахыг урамшуулах зорилгоор сонгогчийн боловсролд зориулсан шторкийг телевиз, радиогоор цацаж эхэлжээ. Мөн үүнтэй адил төстэй мэдээлэл агуулсан сурталчилгааны хуудсыг сонин хэвлэлээр нийтэлж эхэлжээ.

⁸ Жишээлбэл, МУЕСТХ-ийн 48.1-р зүйлийн дагуу хэсгийн хорооны бүрэлдэхүүн сонгуулийн бэлтгэл ажлыг сонгуулийн өдрийн өглөөний 07:00 цагт дуусгасан байх ёстойн дээр, мөн энэ цагт санал хураах байр санал авахаар нээгдэх ёстой. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-ны УХА-чид аймаг, нийслэлийн хороод хэсгийн хороодын гишүүдийг тус бүрийн хэсгийн хороон дээрээ 6:00, эсвэл 6:30 цагт бэлэн байж, бэлтгэл ажлаа 7:00 цаг гэхэд дуусгахыг хүссэн гэж мэдээллээ.

⁹ Өргөдөл, гомдлын тухай дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 5-р хэсгээс үзнэ үү.

¹⁰ Холбогдох зардлыг үүрэн холбооны операторууд хариуцана. <http://gec.gov.mn/details/793>-аас үзнэ үү.

¹¹ Нийт 6,494 саналын хуудсыг гадаадад байгаа иргэдэд, 1,893,207 хуудсыг дотоодын сонгогчдод зориулан хэвлэжээ.

IV. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ

Монгол улсад байнгын, хараат бус хэвлэл мэдээллийн зөвлөл байдаггүй. 2006 оны сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн хүрээнд СЕХ-ны 2013 оны 5-р сарын 22-ны өдрийн тогтоолоор байгуулсан Хэвлэл мэдээллийн түр зөвлөл нь “хэвлэл мэдээллийн орчинд нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгааг тэнцвэртэй байх”-ыг хянах, мөн үүнтэй холбоотой өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх зорилготой ажээ.¹² ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-нд мэдээлснээр Хэвлэл мэдээллийн зөвлөл нь 5-р сарын 23-нд анх хуралдсанаасаа хойш дахиж хуралдаагүй ба иргэдээс гомдол хүлээж аваагүй байна.

СЕХ болон Харилцаа холбооны зохицуулах хорооны 4-р сарын 5-ны өдрийн хамтарсан тогтоолын дагуу “телевиз радиогоор дамжуулж буй Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгаанд мониторинг хийх” үүрэг хүлээсэн ШӨХТГ нь 6-р сарын 3-ны өдөр хийсэн хэвлэлийн бага хурлын үеэрээ МАН-аас гаргасан гурван гомдлын тухай танилцууллаа.¹³ Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж сонгуулийн сурталчилгаа албан ёсоор эхлэхээс өмнө сурталчилгаа хийсэн гэх гомдлыг хэрэгсэхгүй болгож,¹⁴ арилжааны NBS телевизийн мэдээний цагаар нэвтрүүлэгч санаатайгаар үсэг өөрчлөн Б.Бат-Эрдэнийн сонгуулийн сурталчилгааны уриаг нь гуйвуулсан¹⁵ гэх гомдлын дагуу тус телевизийн хоёр сэтгүүлчийг тус бүр нэг сарын цалингаар нь торгон, эфирээр гурван удаа уучлалт хүсэх арга хэмжээ авсан тухай мэдээллээ. Гурав дахь гомдол болох нэр дэвшигч Ц.Элбэгдоржийн Даланзадгад хотын иргэдтэй хийсэн уулзалтыг орон нутгийн телевиз 90 минут нэвтрүүлсэн тухай асуудлыг хараахан шийдвэрлээгүй байна.¹⁶ ШӨХТГ нь уг мэдээллээс хойш ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-нд мэдээлснээр АН болон МАН-аас нэмэлт гомдлууд хүлээж авсан байна. Тухайлбал, АН-аас хүлээж авсан нэг гомдолд 5-р сарын 29-нөөс 30-ны хооронд цацсан МАН-ын улс төрийн сурталчилгаагаар АН-ын нэр дэвшигчийн нэр төрд халдан, гутаан доромжилсон тухай дурьджээ. Үүний хариуд ШӨХТГ нь МАН-д сануулга өгсөн байна.¹⁷

ШӨХТГ нь техник төхөөрөмж, арга зүйн дутмагаас үүдэн гарч болзошгүй зөрчлийг илрүүлэх зорилгоор хэвлэл мэдээллийн чанарын болон тоон мониторингийг хийдэггүй. Тиймээс телевиз, радиогийн нэвтрүүлгүүдийг бичиж авах ажлыг арилжааны Максима Консалтинг компаниар гэрээлэн гүйцэтгүүлж, харин ШӨХТГ нь зөвхөн өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэж байна.

¹² Хэвлэл мэдээллийн зөвлөлийн бүрэлдэхүүн нь АН, МАН, МАХН болон Монголын сэтгүүлчдийн холбоо, Глоб Интэрнэйшнл ТББ-аас тус бүр нэг төлөөлөгчөөс бүрдэх бөгөөд зөвлөл нь СЕХ-нд зөвлөх үүрэгтэй ажилладаг.

¹³ МУЕСТХ-д ШӨХТГ-ыг телевиз, радиогийн нэвтрүүлэгт мониторинг хийх талаар тусгайлан заагаагүй ба зөвхөн ХХЗХ нь ШӨХТГ-аас гаргасан саналыг үндэслэн тусгай зөвшөөрлийг 3 хүртэлх сарын хугацаагаар цуцална гэжээ. СЕХ болон ХХЗХ-ны 4-р сарын 5-ны өдөр гаргасан хамтарсан тогтоолын 4.7 дахь заалтын дагуу хуулиар хүлээсэн олон нийтэд үйл ажиллагаагаа тайлагнах үүрэгтэй боловч өргөдөл гомдол, мөн хэвлэл мэдээллийн мониторингийн талаарх мэдээлэл ШӨХТГ-ын цахим хуудаст байхгүй байна.

¹⁴ ЕАБХАБ/АИХЭГ-аас Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг ажиглах хорооны урьдчилсан тайлан №1 (5-р сарын 10-наас 6-р сарын 3-ны өдрүүд)-ийг үзнэ үү. <http://www.osce.org/odihr/elections/102411>

¹⁵ “Эвийг эрхэмлэж, зөвийг дэмжинэ” гэх уриаг “Эдийг эрхэмлэж, зөвийг дэмжинэ” гэж уншжээ. ШӨХТГ уриаг амаар ч, бичгээр ч буруу хэлж, бичсэн учраас санаатайгаар үйлдсэн гэж дүгнэжээ.

¹⁶ Уг уулзалтыг 5-р сарын 28-нд орон нутгийн Алтан Говь, Говийн нар, Best ТВ-ээр тус тус нэвтрүүлж, маргааш нь давтан гаргасныг Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 39.3, 39.8 зүйлийг зөрчсөн гэж МАН үзсэн байна. 39.3-р зүйлд зааснаар сонгуулийн сурталчилгааны төлбөртэй нэвтрүүлэг нь нэр дэвшигч болон тухайн телевизийн хооронд байгуулсан гэрээнд үндэслэх ёстой бөгөөд нийт нэвтрүүлгийн хугацаа нь хоногт нэг цагаас хэтрэхгүй байна гэжээ. 39.8 дахь заалтаар СЕХ болон ХХЗХ-г улс төрийн сурталчилгаанд зориулсан нэвтрүүлгийн журмыг хамтран боловсруулна гэжээ.

¹⁷ Харамсалтай нь, ШӨХТГ нэр дэвшигч Б.Бат-Эрдэнийн эсрэг АН-аас гаргасан зөвхөн нэг гомдолтой холбоотой баримтыг ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-нд гаргаж өгсөн. (II бүлэг “Сонгуулийн сурталчилгааны орчин” хэсгийг харна уу).

ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-ноос мониторинг хийж буй телевизүүдийн ажилтнуудын хэлснээр хуулинд заасан зохицуулалтын дагуу мэдээний цагаар сурталчилгааг бүх нэр дэвшигчдэд тэнцвэртэй хийх ёстойгоос гадна улс төрийн сурталчилгааг ч ижил хэмжээтэй явуулах ёстой. САХ-ны хийсэн хэвлэл мэдээллийн анхны мониторингоос харахад Монголын үндэсний олон нийтийн телевизийн хувьд энэ мэдээлэл үнэн байна. Хэдийгээр мониторинг хийж буй бүх телевизээр хэлэлцүүлэг нэвтрүүлгүүд тогтмол явж байгаа боловч одоогийн байдлаар нэр дэвшигчид болон улс төрийн намуудын төлөөллийн хооронд халз мэтгэлцээн зохион байгуулагдаагүй байна.¹⁸ Сэтгүүлчид, цаг үеийн тоймчид болон иргэд өөрсдийн сонирхсон асуултуудаа нэр дэвшигчдээс асуух, мөн түүнчлэн нэр дэвшигчид хоорондоо мэтгэлцэх боломж олгох нэвтрүүлгүүд дутагдаж байна.

V. ӨРГӨДӨЛ ГОМДОЛ

Одоогийн байдлаар ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-нд мэдээлсний дагуу сонгуультай холбоотой өргөдөл гомдлыг СЕХ, цагдаа болон ШӨХТГ хүлээн авч, шийдвэрлэж байна. Өнөөдрийн байдлаар САХ нь СЕХ-нд ирсэн бүх өргөдөл гомдолтой танилцах боломжоор хангагдаагүй байна. СЕХ-нд нийт 380 албан бичиг ирсний дотор тодорхойгүй тооны гомдол байгаагаас 39 нь аймаг, нийслэлийн сонгуулийн хороодын бүрэлдэхүүнтэй холбоотой өргөдөл болохыг СЕХ баталлаа. СЕХ нь эдгээр өргөдөл гомдлыг шийдвэрлэхдээ 9-н АНСХ-дын 28 гишүүнийг өөрчлөн томилсон¹⁹ боловч АНСХ-дын гишүүдийг томилох, чөлөөлөхдөө ямар шалгуурыг ашигласан нь тодорхойгүй байна. АНСХ-дын болон сум, дүүргийн сонгуулийн хороодын бүрэлдэхүүний талаар СЕХ-нд ирүүлсэн хэд хэдэн өргөдөл, гомдол нотлох баримттай байсан ч, хороодын бүрэлдэхүүнтэй холбоотой өргөдөл гомдлыг барагдуулах дээр СЕХ-ноос гаргасан шийдвэрүүд нь үндэслэл, нотлох баримт дурьмаг байгааг САХ болон САХ-ныхонтой уулзсан бусад хүмүүс хэллээ.²⁰ Намын далбааг хуулинд зөвшөөрсөн газраас өөр газар байрлуулсан тухай хоёр гомдлыг тухайн сум, дүүргийн хороод даруй арга хэмжээ авч шийдвэрлэжээ.²¹

МАН-аас нэр дэвшигч сонгуулийн сурталчилгаандаа хуулиар хориглосон амлалт, насанд хүрээгүй хүүхдүүд болон шашин шүтлэгтэй холбогдолтой дүрс, зургийг ашиглаж байгаа тухай АН-ын гомдлыг МУЕСТХ-нд заасны дагуу СЕХ хүлээн авч, шалгуулахаар цагдаагийн байгууллагад шилжүүлжээ.²² АН-ын нэр дэвшигч хуулиар хориглосон амлалт, худал мэдээлэл түгээсэн, төрийн албан хаагчдыг сонгуулийн сурталчилгаандаа хамруулсан талаар МАН-ын

¹⁸ Нэр дэвшигчдийн халз мэтгэлцээнийг сонгуулийн сурталчилгаа дуусах өдөр зохион байгуулна гэж МҮОНРТ-ийн төлөөлөгчид ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-нд мэдээлэв.

¹⁹ СЕХ нь ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-нд аймаг, нийслэлийн сонгуулийн хороодын бүрэлдэхүүнтэй холбоотой дөрвөн шийдвэрийн хуулбарыг танилцуулав. Эдгээрийн гурав нь СЕХ-оос бидний онцгойлон хүссэн, мөн бусад эх сурвалжуудаас олж авсан гомдлуудад өгсөн СЕХ-ны шийдвэрүүд байв. СЕХ-нд ирсэн бүх өргөдөл гомдолтой бүрэн танилцах САХ-ны хүсэлтэнд СЕХ хараахан хариу өгөөгүй байна.

²⁰ Аймаг, нийслэлийн 8 сонгуулийн хорооны бүрэлдэхүүний талаар МАН 3 гомдол гаргасан. Түүнчлэн Дархан-Уул аймаг дахь МАН-ын салбараас тус аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал дахь АН-ын бүлгийн саналаар сонгуулийн хороонд ажиллах эрхгүй төрийн албан хаагчдыг томилсон байна гэх 4 гомдол СЕХ-нд иржээ. Эдгээр гомдлын хариуг хараахан өгөөгүй байна. Зарим хэсгийн хороодод эрх бүхий гишүүд ороогүй тул аймгийн сонгуулийн хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт хийх тухай Дундговь аймгийн иргэдийн хурлаас ирүүлсэн хүсэлтийн хариуг СЕХ мөн өгөөгүй байна. Сүхбаатар аймгийн сонгуулийн хорооны даргын томилгоо (2012 оны УИХ-ын сонгуулийн үеэр сонгуулийн хорооны гишүүний хувьд хоёр удаа хууль бус үйлдэл гаргасан нь шүүхээр тогтоогдсон)-г хууль бус гэсэн гомдлын хариуд түүнийг төрийн байгууллага болон сонгуулийг удирдах олон жилийн туршлагатай сайн төрийн албан хаагч гэсэн хариуг өгчээ.

²¹ Нийслэлийн Чингэлтэй дүүрэг, Дархан-Уул аймгийн Хонгор сумын сонгуулийн хороо.

²² Хуульзүй, дотоод хэргийн яам ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-той уулзахдаа цагдаагийн байгууллагад МУЕСТХ-ийн дагуу ямар эрх үүрэгтэй ажиллах тухай, хууль хэрэгжүүлэх, өргөдөл гомдлын дагуу шалгалт явуулахдаа хараат бус, улс төрийн намын нөлөөгүй ажиллах чиглэл өгсөн тухайгаа хэлсэн. Энэ удирдамж чиглэлийг нууцлалын зэрэгтэй хэмээн САХ-той хуваалцаагүй. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-ны УХА-дын тайлангуудаас харахад цагдаа нар ажил үүргээ сайн мэдэж байна гэсэн дүр зурагтай байна.

зүгээс мөн гомдол гаргажээ²³. МАН одоогийн Ерөнхийлөгчийг сонгуулийн сурталчилгааг эрт эхлүүлсэн тухай ШӨХТГ-г гаргасан гомдлынхоо хувийг ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-нд өгсөн болно.²⁴ Түүнчлэн МАН нь Өмнөговь аймгийн цагдаагийн байгууллагаар гурван асуудал шалгуулахаар хүсэлт гаргаад байна.²⁵

VI. ИРГЭД БА ОЛОН УЛСЫН АЖИГЛАГЧИД

Монгол улсад 6000 гаруй төрийн бус байгууллага (ТББ) бүртгэлтэй байдаг. 2012 оны УИХ-ын сонгуулийг “Шударга сонгуулийн төлөө” уриатайгаар зургаан ТББ-аас бүрдсэн сүлжээ ажиглалт хийж байсан бол, энэ удаагийн сонгуулийг ажиглахаар зөвхөн “Мидас” ТББ санхүүжилт олж авчээ. Тус байгууллага одоогоор СЕХ-той хамтран СТАТ-ийн үйл ажиллагааг турших дээр ажиглалт хийж байна. СЕХ-ноос улс төрийн намуудыг уг төхөөрөмжийг турших хувилбаруудыг боловсруулахад оролцохыг хүссэн байна. Бусад ТББ-ууд сонгуулийн өдрөөс өмнөх үеийг ажигласангүй нь ийн ажиглалт явуулах санхүүжилтгүй, мөн дээрх хугацаанд ажиглалт хийх итгэмжлэл олгох дээр СЕХ-ны зохицуулалт хязгаарлагдмал нөхцлийг үүсгэж байгаагаас үүдэж байна.²⁶

VII. ЕАБХАБ-ЫН АИХЭГ-ЫН САХ-НЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Энэхүү тайлангийн хугацаанд ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ нь үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлж, төрийн албан тушаалтнууд, улс төрийн намууд болон нэр дэвшигчдийн төлөөлөл, сонгуулийн хороод, Үндсэн хуулийн цэц, хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн төлөөлөгчид болон дипломат албаны төлөөлөгчидтэй уулзлаа. САХ-ны дарга нэр дэвшигчидтэй уулзах хүсэлтээ удаа дараалан гаргасан боловч одоогоор уулзалт товлогдоогүй байна. Хөдөө, орон нутгуудад томилогдон ажиллаж буй ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-ны УХА-чид орон нутагт явагдаж буй сонгуулийн бэлтгэл ажил, сурталчилгаанд ажиглалтаа үргэлжлүүлэхийн зэрэгцээ богино хугацааны ажиглагч нарыг хүлээж авахад бэлтгэж байна.

*Энэхүү тайлангийн англи хэл дээрх хувилбар нь албан ёсны хувь болно.
Албан бус орчуулгыг монгол хэл дээр авах боломжтой.*

²³ Энэ тайлангийн “Сонгуулийн сурталчилгааны орчин” гэсэн 2-р хэсгээс дэлгэрэнгүй танилцана уу.

²⁴ ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-ноос гаргасан эхний тайланг харна уу. ШӨХТГ-ын дүгнэлт шийдвэрийг МАН хангалтгүй гэж үзэж, өмнөх гомдлоо дахин гаргажээ. Нийслэлийн цагдаагийн газраас эхний гомдолд МУЕСТХ-ийн холбогдолгүй заалтыг үндэслэн хариу өгсөн тул уг хэргийг дахин шалгуулах хүсэлтээ МАН гаргажээ.

²⁵ Гурван гомдол бүгд сонгуулийн сурталчилгаа явуулах журам зөрчсөн тухай байв. Цагдаагийн байгууллагаас нэг гомдлын тухайд хууль зөрчсөн үйлдэл биш байна гэсэн хариуг өгсөн ба уг гомдлоо шүүхэд гаргаж болохыг мөн зөвлөжээ.

²⁶ СЕХ-ны 23 дахь тогтоолын 2.2-р зүйлд “Сонгууль явагдах өдрийн тов зарлагдсанаас хойш 15 хоногийн дараа ТББ-ууд сонгууль ажиглах хүсэлтээ бичгээр гаргаж, СЕХ-нд ирүүлнэ” (өөрөөр хэлбэл сонгууль явагдах өдрөөс 50 буюу түүнээс дээш хоногийн өмнө) гэж заажээ.